



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/177

Хэрлэн сум

Хэнтий аймаг байгуулагдсаны 100 жилийн  
ойн баяр наадмыг зохион байгуулах, бэлтгэл  
ажил хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Баяр наадмын хорооны бүрэлдэхүүн батлах тухай" 44 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын төлөвлөгөө, төсөв гаргаж батлуулан, бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд, гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд аймгийн баяр наадмын бэлтгэл ажил хангах ажлын хэсгийн дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



100 ЖИЛИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
Нарийн бичгийн дарга:	Н.Зоригтбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	С.Оюун-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга	
А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга	
Ц.Бат-Эрдэнэ	Авто тээврийн төвийн дарга	
Г.Лхагвабаатар	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	

Т.Лхагвадорж	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга
С.Болд	БЗӨБЦТС-ийн харьяа Хэнтий цахилгаан түгээх Сүлжээ салбарын захирал
Г.Батгэрэл	“Хэнтий-Ус” ХХК-ийн захирал
Т.Баяржаргал	Хэнтий нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын захирал
Г.Нямхатан	Политехникийн коллежийн захирал
Д.Батболд	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймгийн салбарын тэргүүн
Д.Энхзаяа	Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
Ч.Нарантуяа	“Хан Бүргэд хаан” ХХК-ийн захирал
Ж.Сэргэлэнбаатар	“Боржигон нутаг ХХК” захирал
Ц.Оюун-Эрдэнэ	“Мэргэн түмэн” ХХК-ийн захирал
Г.Мөнх-Заяа	“99 хоршоо” ХХК-ийн захирал